

Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Компанийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуульд тус тус заасны дагуу компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн төрөл, хэлбэр, мэдээллийг компанийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, олон нийтэд тайлагнах, хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- 1.2.1. “мэдээллийг нээлттэй болгох” гэж хууль тогтоомж, компанийн засаглалын кодекс болон энэ журамд заасан мэдээллийг компанийн цахим хуудас, эсхүл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр холбогдох этгээдэд саадгүй хүргэх боломжийг хангасан бусад хэлбэрээр дамжуулан хүргэхийг,
- 1.2.2. “хугацаат тайлагнал” гэж хувьцаа эзэмшигчдийн хурал болон хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх зорилгоор компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулсан тайланг,
- 1.2.3. “тухай бүр мэдээлэх мэдээлэл” гэж хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц компанийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон нөхцөл байдалтай холбоотой мэдээллийг;
- 1.2.4. “дотоод мэдээлэл эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1-д заасан дараах этгээдийг хэлнэ:
- үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон тэдгээрийн холбогдох этгээд;
 - албан үүргээ хэрэгжүүлэх, гэрээ, хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан этгээд болон тэдгээрийн холбогдох этгээд.

1.3. Баримтлах зарчим:

- 1.3.1. Иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх,
- 1.3.2. Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлттэй байх,



- 1.3.3. Мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа шуурхай, хялбар байх
- 1.3.4. Мэдээлэл, үйлчилгээ нь ойлгомжтой, үнэн зөв, бүрэн байх,
- 1.3.5. Мэдээллийг ашиглах үйл ажиллагаанд иргэн, хуулийн этгээд эрх тэгш байх.

Хоёр. Хугацаат тайлагналын мэдээлэл

- 2.1. Хугацаат тайлагналд компанийн хагас, жил, жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан хамаарна.
- 2.2. Хугацаат тайлагналын мэдээллийг бүрдүүлж хувьцаа эзэмшигч, олон нийтэд мэдээлэх ажлыг компанийн гүйцэтгэх удирдлага зохион байгуулах ба ТУЗ мэдээллийг үнэн зөв, бүрэн, цаг хугацаандаа хүргэж байгаад хяналт тавина.
- 2.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд “Компанийн засаглалын кодекс”-т заасан мэдээллийг заавал тусгасан байна.

Гурав. Тухай бүр мэдээлэл мэдээлэл

- 3.1. **Тухай бүр нийтэд нээлттэй болгох мэдээлэлд дор дурдсан нөхцөл байдал, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тооцох ба тухайн нөхцөл байдал үүссэнээс хойш ажлын нэг өдөрт багтааж мэдээллийг нээлттэй болгоно. Үүнд:**
 - 3.1.1. Компанийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, бизнест шууд нөлөө үзүүлэхүйц гэрээ, хэлцэл байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, дуусгавар болгох, татгалзах, гэрээний хугацаа дууссан,
 - 3.1.2. Шүүх, прокурор, төрийн эрх бүхий байгууллагаас үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан болон компанийг хариуцагчаар татаж, захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн, шүүхээс дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу эрх хүлээн авагч үл томилогдсон,
 - 3.1.3. Нийт активын 25 хувь ба түүнээс дээш хэмжээтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалсан эсхүл бусад компанийн хяналтын багц худалдан авсан талаарх мэдээлэл, холбогдох гэрээ, хэлцэл;
 - 3.1.4. Компанийн эрх бүхий этгээдээс СТОУС-ын дагуу компанийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзэн дахин үнэлгээ хийхээр шийдвэрлэсэн тохиолдолд холбогдох шийдвэр, уг шийдвэрийг гаргах болсон нөхцөл, шаардлага, үнэ цэнэ нь буурсан хөрөнгө болон хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хэмжээ эсхүл хязгаарын тооцоолол;
 - 3.1.5. Компанийн эрх бүхий этгээдээс компанийн өмнөх жилүүдийн санхүүгийн тайланд алдаа гарсан гэж үзсэн бол алдаатай санхүүгийн тайлангууд, алдаа гарсан гэж үзэх үндэслэл;

- 3.1.6. Компанийн хяналтын багцыг бусад этгээдэд шилжүүлэх;
- 3.1.7. Компанийн эрх бүхий албан тушаалтан, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг томилж, чөлөөлөх;
- 3.1.8. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах;
- 3.1.9. Гүйцэтгэх удирдлагыг үүрэгт ажлаас чөлөөлөх;
- 3.1.10. Компанийн ёс зүйн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;
- 3.1.11. Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, зах зээлд нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулсан,
- 3.1.12. Үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл болон барааны тэмдэг эзэмших эрх хүчингүй болсон эсхүл цуцлагдсан;
- 3.1.13. Оноосон нэр, үндсэн захиргаа, оршин байх хаяг байршил өөрчлөгдөх, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, эсхүл татан буулгах;
- 3.1.14. Үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөх, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогсох;
- 3.1.15. Компани төлбөрийн чадваргүй болох, татан буулгах чиглэлээр гаргасан шийдвэр;
- 3.1.16. Шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл
- 3.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга энэхүү журмын 3.1-д заасан мэдээллийг нээлттэй болгох ба гүйцэтгэх удирдлага тухайн мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

Дөрөв. Компанийн талаар мэдээлэл авах

- 4.1. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь холбогдох хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэйгөөр хуулбарлан авах боломжийг хувьцаа эзэмшигчид олгох үүрэгтэй.
- 4.2. Компанийн цахим хуудсанд үйл ажиллагааны мэдээлэл болон “Компанийн засаглалын кодекс”-т заасан бодлогын баримт бичгүүд, дотоод дүрэм, журам, зааврыг байршуулж, цаг тухайд нь шинэчлэн хөрөнгө оруулагч, бусад оролцогч талуудыг мэдээллээр хангана.

Тав. Мэдээллийг хадгалах

- 5.1. Нийтэд мэдээлсэн мэдээллийн баримт бичгийг 5 жилийн хугацаагаар хадгалах ба уг хугацаа дуусмагц архивт шилжүүлнэ.
- 5.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь нийтэд мэдээлсэн мэдээллийн баримт бичгийг хүлээн авах, хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивд шилжүүлэх ажлыг

хариуцаж гүйцэтгэнэ.

Зургаа. Дотоод мэдээлэл

- 6.1. Дотоод мэдээлэл эзэмшигч нь компанийн дотоод мэдээллийг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан мэдээллийг нээлттэй болгохоос өмнө санамсаргүй болон санаатайгаар ашиглах, бусдад мэдээлэх, дамжуулах, олж авах нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.
- 6.2. Дотоод мэдээллийг цахим хуудас, эсхүл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тухайн этгээдэд саадгүй хүргэх боломжийг хангасан бусад хэлбэрээр нийтэд мэдээлж, ил болгоно.
- 6.3. Компани нь хуурамч, бусдыг төөрөгдүүлсэн мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглоно.

Долоо. Бусад мэдээлэл

- 7.1. Мэдээллийг нээлттэй болгоход компанийн ТУЗ-өөс хяналт тавина.
- 7.2. Нээлттэй болгосон мэдээлэлд алдаа, зөрүү гарсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч залруулна.
- 7.3. Энэхүү журмын гүйцэтгэлийн үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор ТУЗ нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.

oOo